




ЭКОСУМ

САНХҮҮГИЙН ТАЙЛАН



2018-2019

ЕРӨНХИЙ

Тус тайланд Экосум ТББ-ын 2018 оны 10 сарын 3-аас (байгууллага албан ёсоор бүртгэгдсэн огноо) 2019 оны 12 сарын 31 хүртэлх санхүүгийн бүх орлого, зарлагын дэлгэрэнгүйг тайлагнав.

Тус тайланд ₮рөг (₮) болон евро (€)-ны хөрвүүлэх ханшийг 1 € нь 3000 ₮рөгтэй тэнцэхээр ашиглав.


ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД

2018-2019 онд Экосум-ын нийт орлого 43,614,738 ₮ буюу ; € 14,538 байв.

Олон нийтийн хандив нийт орлогын үндсэн (54%) (23,525,260 ₮ буюу € 7,842) хэсгийг бүрдүүлж байна. Эдгээр хандивын дийлэнхийг байгууллага үүсгэн байгуулагдахад GoFundMe сайтад зохион байгуулсан олон нийтээс санхүү босгох ажлын үеэр ирүүлсэн.

Нийт орлогын 45%-ийг (19,739,478 ₮ буюу € 6,580) төслийн санхүүжилт эзэлж байна. Үүнд Азийн сангаас “хогний менежмент” төслийн хүрээнд ирүүлсэн (нийт 13,739,478 ₮ буюу € 4,580) санхүүжилт болон Хишиг-Өндөр сумын ЗДТГ-тай хийсэн хамтран ажиллах гэрээний хүрээнд олгосон (6,000,000 ₮ буюу € 2,000) багтна.

Гишүүний татвар нийт орлогын 1% -ээс бага (350,000 ₮ буюу € 117) хэсгийг бүрдүүлж байна. .




НИЙТ ЗАРЛАГА БОЛОН ДАНСНЫ ТЭНЦЭЛ

2018-2019 оны нийт зарлага 11,067,900 ₮ буюу € 3,689 байв.

2019 оны 12 сарын 31-ны байдлаар дансны тэнцэл эерэг буюу 32,546,838 ₮, € 10,849 байна. 2018-2019 онд зарлага багатай байсан бөгөөд нийт санхүүжилтийн гуравны хоёр нь 2019 оны эцэст орж ирсэн тул 2020 онд зарцуулагдана.

Нийт зарлагын 68%-ийг (7,545,065₮ буюу € 2,515) “хогны менежмент”-ийн төсөл, 11% (2,362,385₮ буюу € 787)-ийг “газар тариалан”-ийн төсөл эзэлж байна. Үлдсэн 21%-ийг (2,362,385₮ буюу € 787) үйл ажиллагааны үндсэн зардал эзэлж байна.




ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРДАЛ

Ажлын томилгооны зардал үндсэн үйл ажиллагааны зардлын бараг тал (49%) хувь (1,157,485₮ буюу € 385)-ийг эзэлж байна. Эдгээр зардлуудад Улаанбаатарт хийгдсэн ажлын уулзалтууд болон бусад Экосум-ын үйл ажиллагуунуудтай уялдаатай байр, унаа, хоолны зардлууд багтна.

Материаллаг тоног төхөөрөмж үйл ажиллагааны үндсэн зардлын 26% болох (620,000₮ буюу € 207)-ыг эзэлж байна. Үүнд принтер гэх мэт оффисын хэрэглэгдэхүүнүүд багтна.

Харилцаа холбооны зардал 24% (555,000₮ буюу € 185)-ийг эзлэх ба утас, интернетийн төлбөр багтна.

Банкны төлбөр үндсэн үйл ажиллагааны зардлын 1% (29,900₮ буюу € 10)-ийг эзэлж байна.




“ХОГНЫ МЕНЕЖМЕНТ” ТӨСЛИЙН ЗАРДАЛ

Материал, тоног төхөөрөмж “хогны менежмент”-ийн төсөлтэй уялдаатай нийт зардлын дийлэнх (82%) (6,191,695₮ буюу € 2,064)-ийг эзэлж байна. Эдгээр зардлуудад хуванцар дахин боловсруулах машин барихад шаардлагатай багаж тоног төхөөрөмж, түүхий эд болон бусад (уут, тараах материал, ханын самбар гм) зүйлс багтна.

“Хогны менежмент”-ийн төслийн зардлын 12% (899,370₮ буюу € 300)-ийг хүний нөөцийн зардал эзэлж байна. ЭкоСум ТББ-ын гишүүд 2018-2019 онуудад зөвхөн сайн дураар ажилласан тул дээрх хүний нөөцийн зардалд зөвхөн олон улсын сайн дурын ажилтнуудын хоол хүнсний зардал багтаж байна.

Зөвхөн “хогны менежмент”-ийн төсөлтэй уялдаатай аялалын зардал төслийн нийт зардлын 5% (354,000₮ буюу € 118)-ийг эзэлж байна. .

Гэрээт үйлчилгээ (орчуулга)-ний зардал төслийн нийт өртгийн 1% (100,000₮ буюу € 33) байна.



“ГАЗАР ТАРИАЛАН”-ИЙН ТӨСЛИЙН ЗАРДАЛ

“Газар тариалан”-ийн төсөлтэй уялдаатай нийт зардлын 72%-ийг материал, тоног төхөөрөмжийн худалдан авалт эзэлж байна (835,000₮ буюу € 278). Эдгээрт Экосум-ын газар тариалангийн талбайг хашиж хамгаалахад зориулсан тор болон бусад шаардлагатай багаж зэрэг багтна.

Гэрээт үйлчилгээний зардал (орчуулга) төслийн нийт зардлын 26% (306,000₮ буюу € 102)-ийг эзэлж байна.

Хүний нөөц (сайн дурын ажилтнуудын хоол хүнс) “газар тариалан”-ийн төслийн зардлын 2% (19,450₮ буюу € 6) байна.

2018-2019 онд “газар тариалан”-ийн төсөлтэй хамааралтай томилгооны зардал гараагүй.

